



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН
ТУШААЛ

2025 оны 06 сарын 06 өдөр

Дугаар A/1200

Улаанбаатар хот

“Профессор, багшийн ажлын гүйцэтгэлийг
кредитээр тооцож, үнэлэх журам”-ыг
шинэчлэн батлах тухай

ШУТИС-ийн дүрмийн 2.1.2, 4.9.15, 4.9.16 заалт, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 08 дугаар тогтоол, ШУТИС-ийн Ректорын зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Профессор, багшийн ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталж, 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Журмыг шинэчлэн баталсантай холбоотой ШУТИС-ийн 2018 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн А/159 дугаар “Профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам”-ыг шинэчлэн батлах тухай”, 2018 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А/184 дугаар “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” захирлын тушаал, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 07 дугаар “Профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, ШУТИС-ийн 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/152 дугаар “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/40 дугаар “Хичээлийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах тухай”, 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/05 дугаар “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/265 дугаар “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/266 дугаар “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/396 дугаар “Профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай” захирлын тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжүүлж ажиллахыг Сургалт, оюутны хөгжил эрхэлсэн проректор (Н.Эрдэнэхүү), Эрдэм шинжилгээ, инновац эрхэлсэн проректор (Д.Цолмонбаатар), бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.

РЕКТОР

Т.НАМНАН



• 367041072



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06-ны өдрийн А/200 дугаар тушаалын хавсралт

	ПРОФЕССОР, БАГШИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ КРЕДИТЭЭР ТООЦОЖ, ҮНЭЛЭХ ЖУРАМ	2018
	ЭХНИЙ ХЭВЛЭЛТ Оорчилсан огноо	2025
	Өөрчлөлтийн дугаар	9

ПРОФЕССОР, БАГШИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ КРЕДИТЭЭР ТООЦОЖ, ҮНЭЛЭХ ЖУРАМ

Улаанбаатар 2025 он



АГУУЛГА

ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06-ны өдрийн А/200 дугаар тушаалын хавсралт

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ.....	3
ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ	3
ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ	4
ТАВ. ТАЛУУДЫН ЧИГ ҮҮРЭГ	6
ЗУРГАА. КРЕДИТИЙН НООГДОЛ БА ГҮЙЦЭТГЭЛ ТООЦОХ НӨХЦӨЛҮҮД.....	7
ДОЛОО. СУРГАЛТЫН АЖЛЫН КРЕДИТИЙН ТООЦОО	12
НАЙМ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦЫН АЖЛЫН КРЕДИТИЙН ТООЦОО .	19
ЕС. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН АЖЛЫН КРЕДИТИЙН ТООЦОО.....	24



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06-ны өдрийн А/200 дугаар тушаалын хавсралт

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар ШУТИС-ийн профессор, багш нарын тухайн хичээлийн жилд гүйцэтгэсэн ажлын үр дүнг тооцож, үнэлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Тус журмаар зохицуулаагүй асуудлыг Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Инновацийн тухай хууль, бусад хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, ШУТИС-ийн дүрэм, журмаар зохицуулна.

1.3. Профессор, багшийн ажлын гүйцэтгэлийг сургалт; эрдэм шинжилгээ, инновац; мэргэжлийн үйлчилгээ, нийгмийн хариуцлага гэсэн 3 чиглэлээр тодорхойлж кредитээр тооцож үнэлнэ.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. ШУТИС-ийн профессор, багш нар болон бусад оролцогч талуудын сургалт; эрдэм шинжилгээ, инновац; мэргэжлийн үйлчилгээ, нийгмийн хариуцлагын чиглэлээр гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг үнэлж тогтооно.

ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

- 3.1. Боловсролын ерөнхий хууль
- 3.2. Дээд боловсролын тухай хууль
- 3.3. Инновацийн тухай хууль
- 3.4. Хөдөлмөрийн тухай хууль
- 3.5. БШУ-ны сайдын “Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”
- 3.6. БШУ-ны сайдын “Сургалтын агуулгыг багц цагаар тооцох, багц цагийг дүйцүүлэх журам”
- 3.7. ШУТИС-ийн бакалавр оюутны сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам
- 3.8. ШУТИС-ийн ахисан түвшний сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам
- 3.9. ШУТИС-ийн мэргэжлийн тэнхимиийн үйл ажиллагааг зохицуулах журам



ШУТЫС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06-ны өдрийн А/200 дугаар тушаалын хавсралт

ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

4.1. Профессор, багшийн 1 кредитийн ачаалал гэж профессор, багшийн сургалт, эрдэм шинжилгээ, инновац, мэргэжлийн үйлчилгээ, нийгмийн хариуцлага чиглэлээр гүйцэтгэсэн 48 цагийн хөдөлмөрийг;

4.2. Сургалтын ажлын кредит /цаашид А гэх/ гэж тухайн профессор багшийн хичээл заах, дадлага, туршилт, судалгааны ажил удирдах болон сургалттай холбоотой бусад үйл ажиллагаагаар гүйцэтгэсэн кредитийг;

4.3. Эрдэм шинжилгээ, инновацын ажлын кредит /цаашид Б гэх/ гэж профессор, багшийн эрдэм, шинжилгээ судалгааны ажил, төсөл гүйцэтгэх, өгүүлэл, илтгэл бичих, хэлэлцүүлэх зэрэг үйл ажиллагаагаар гүйцэтгэсэн кредитийг;

4.4. Мэргэжлийн үйлчилгээ, нийгмийн хариуцлагын ажлын кредит /цаашид В гэх/ гэж профессор, багшийн нийгэм олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа болон мэргэжлийн үйлчилгээгээр гүйцэтгэсэн кредитийг;

4.5. Хичээлийн цаг гэж байгалийн цагийн 50 минутиг; Хоёр цагийн хичээлийг дунд нь завсарлагагүйгээр 90 минутад багтаан явуулж болно.

4.6. Хичээлийн кредит гэж тухайн хичээлийн суралцахуйн үр дүнг оюутанд эзэмшүүлэх зорилгоор төлөвлөсөн хичээлийн нийт кредитийг; Хичээлийн нийт кредит нь багшийн хичээл бэлтгэх, хичээлийг удирдан явуулах болон оюутантай ажиллаж зөвлөгөө өгөх, хичээлийн явцад болон эцэст суралцагчийг үнэлэхэд зарцуулах цагийн нийлбэрээр тооцогдох ба 48 цаг тутамд хичээлийн 1 кредит харгалзана.

4.7. Хичээлийн хэлбэр гэж профессор багш хичээлийг удирдан явуулахад ашиглаж байгаа сургалтын хэлбэрийг; Хичээл нь лекц, семинар, лаборатори, дадлага, төсөл, дипломын төсөл, төгсөлтийн ажил гэх мэт хэлбэртэй байх бөгөөд хэлбэрээс хамаарч багшийн сургалтын ажлыг гүйцэтгэлийг ялгаатай байдлаар үнэлнэ.

4.8. Хичээлийн задаргаа гэж тухайн хичээлийн нийт кредитэд үндэслэн 1 долоо хоногт орох хичээлийн цагийг лекц, семинар/практик, лаборатори/дадлага, хичээл бэлтгэх/оюутантай ажиллах цаг гэсэн задаргааны дагуу гаргасан төлөвлөлтийг; Лекцийн 1 цаг тутамд 2 цагийн, семинар/практик, лаборатори/дадлагын 1 цаг тутамд 0.5 цагийн хичээл бэлтгэх/оюутантай ажиллах цагийг төлөвлөнө.

4.9. Лекцийн хичээл гэж шинжлэх ухааны онолын мэдлэгийг системтэй өгөх зорилготой багшийн тайлбарлан ярих болон сурган заах арга зүйн бусад арга, хэрэгслийг ашиглан явуулж буй сургалтын хэлбэрийг;

4.10. Семинар, практикийн хичээл гэж онолын мэдлэгийг гүнзгийрүүлэн бататгах, зарим хичээлийн онцлогоос хамаарч онол, практикийн мэдлэг, чадварыг хослуулан олгоход чиглэсэн сургалтын хэлбэрийг; Семинар, практикийн хичээл нь лекцээр эзэмшсэн мэдлэгийг бататгах зорилготой эсвэл дангаараа семинар, практик хэлбэртэй байж болно.

4.11. Лабораторийн хичээл гэж туршилт судалгааны зориулалтаар бэлтгэсэн тусгай орчинд онолын мэдлэгийг баталгаажуулж чадвар, дадлага олгох, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтын хэлбэрийг;

4.12. Дадлагын хичээл гэж суралцагчийн онолын мэдлэг, чадварыг практик үйл ажиллагаатай холбон бататган гүнзгийрүүлэх, дадал эзэмшүүлэх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, бие даан болон багаар ажиллах чадварт сургах зорилготой сургалтын хэлбэрийг; дадлагын хичээлийг танилцах болон дипломын өмнөх; үйлдвэрлэлийн, хээрийн, мэргэжлийн болон орчуулгын зэргээр ангилна.



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06-ны өдрийн А/200 дугаар тушаалын хавсралт

4.13. Төслийн хичээл гэж суралцагч баагар эсвэл ганцаарчилсан байдлаар асуудал шийдвэрлэх төсөл хэлбэрийн даалгавар гүйцэтгэж хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагаа практик хэрэглээ болгох сургалтын хэлбэрийг; Энэ нь төсөлд суурилсан сургалтын хэлбэрээр зохион байгуулагдах хичээл байх бөгөөд суралцагч 1-р курсээсээ эхлэн хичээлийн жил бүр үе шаттайгаар судлахаар төлөвлөгдсөн байж болно.

4.14. Бакалаврын дипломын төсөл гэж оюутан бакалаврын зэргийн боловсрол эзэмшсэнээ нотлон харуулах зорилгоор тухайн хөтөлбөрөөр эзэмшсэн суралцахуйн үр дүнгүүд буюу мэдлэг чадвар, хандлагаа ашиглан гүйцэтгэх тодорхой асуудал шийдвэрлэх даалгавар бүхий төслийн ажлыг;

4.15. Төгсөлтийн шалгалт гэж оюутан тухайн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдийг хэр түвшинд эзэмшсэнийг үнэлж дүгнэх зорилгоор төгсөлтийн өмнө зохион байгуулах нэгдсэн шалгалтыг;

4.16. Магистрын төгсөлтийн ажил гэж шинжлэх ухааны тодорхой асуудлыг гүнзгийрүүлэн судалж туршилт, боловсруулалт, дүн шинжилгээ хийх замаар судалгааны үр дүнг тодорхой үзэл баримтлалд үндэслэн нотолж, улмаар асуудлын шийдлийг дэвшүүлсэн санал, дүгнэлт, зөвлөмж бүхий судалгааны ажлыг;

4.17. Докторын диссертаци гэж шинжлэх ухааны тодорхой салбарын мэдлэгийн хүрээг тэлж ач холбогдол бүхий зорилтыг шийдсэн, эсвэл улс орны нийгэм, эдийн засагт үр өгөөжтэй практик асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр шийдсэн, урьд өмнө хийгдсэн, мэдэгдэж буй бусад шийдлүүдтэй харьцуулж, шүүмжлэлтэйгээр шинэлэг талыг нээн харуулсан, зохих загвар, шаардлагыг баримталсан, тухайн сэдвээр шинэ мэдлэг мэдээлэл, үндэслэл, онол практикийн дүгнэлт гаргасан эрдэм шинжилгээний ажлыг;

4.18. Сургалтын үйл ажиллагаа гэж лекц, семинар, практик, лаборатори гэх мэт хэлбэрээр хичээлийг бэлтгэх, хүргэх, зөвлөгөө өгөх, хэлэлцүүлэг хийх, явцын болон улирлын шалгалт, даалгавар, бие даалтын ажлыг шалгаж дүгнэх зэрэг цогц үйл ажиллагаагаар багш болон суралцагчийн хооронд үүсэх харилцааг;

4.19. Танхимиын сургалт гэж урьдчилан боловсруулж баталсан хичээлийн хуваарийн дагуу зөвхөн сургалтын анги, танхимд зохион байгуулах сургалтын үйл ажиллагааг;

4.20. Танхимиын бус сургалт гэж сургалтын удирдлагын систем(LMS), цахим сургалтын платформ ашиглан бодит хугацаанд(online) эсвэл бодит бус хугацаандoffline) зохион байгуулах сургалтын үйл ажиллагааг;

4.21. Хосолсон сургалт гэж танхимиын сургалт, танхимиын бус сургалтыг тодорхой хувь харьцаагаар хослуулсан зохион байгуулах сургалтын үйл ажиллагааг;

4.22. Хичээлийн иж бүрэн материал гэж тухайн хичээлээр сургалт явуулахад ашиглах хичээлийн хөтөлбөр, лекц, семинар, лаборатори, практик ажлын материал, гарын авлага, суралцагч нэмэлтээр уншиж судлах шаардлагатай үндсэн болон нэмэлт ном, сурх бичиг, цахим материал, явцын болон улирлын шалгалтын материал, бие даалтын даалгавар, түүнийг дүгнэх аргачлал зэрэг багшийн бэлтгэх шаардлагатай бүх төрлийн хэрэглэгдэхүүнийг;

4.23. Цахим хичээл гэж мэдээлэл холбооны технологи ашиглан зохиомжлон бэлтгэсэн тусгай хичээлийг; Цахим хичээл нь бүрэн цахим болон холимог цахим хичээл хэлбэртэй байж болно.

4.24. Бүрэн цахим хичээл гэж хичээлийн бүх хэлбэр(лекц, семинар, лаборатори гэх мэт)-ийг бодит бус хугацаандoffline) цахим хэлбэрээр зохион байгуулах боломжтойгоор зохиомжлон бэлтгэсэн хичээлийг;



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06-ны өдрийн А/200 дугаар тушаалын хавсралт

4.25. Холимог цахим хичээл гэж хичээлийн зарим хэлбэрийг бодит хугацаанд(online) эсвэл бодит бус хугацаанд(offline) цахим хэлбэрээр зохион байгуулахаар зохиомжлон бэлтгэсэн хичээлийг;

4.26. Тонгоруу сургалт гэж хичээлийн материалыг урьдчилан цахимаар хүргэж, дараа нь түүнийг ашиглан танхимиын сургалтын цаг дээр бататгах, асуудал шийдвэрлэх, хэлэлцүүлэг хийх гэх мэт аргуудаар сургалт явуулах хэлбэрийг;

4.27. Нээлттэй хичээл гэж сургалтад шинэ арга, технологи нэвтрүүлснээ нотлон харуулах, өөрийн арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор нэгж хичээлийн цаг дээр тусгайлан бэлтгэж заасан хичээлийг;

4.28. Нотлох баримт гэж тухайн үйл ажиллагаа, үр дүнг илтгэх баримт бичиг, холбогдох мэдээллийг;

4.29. Албан тушаалын нэг кредитийн үнэлгээ гэж профессор, багшийн тухайн албан тушаалд харгалзах ректорын тушаалаар баталсан цалингийн сүлжээний үндсэн цалинг нэг сарын дундаж ноогдол 2 кредитэд харьцуулсан харьцааг;

4.30. Хүндэтгэн үзэх шалтгаан гэж хүнд өвчтэй, эмчилгээ хийлгэж байгаа, өвчтөн асарсан(эхнэр, нөхөр, төрсөн хүүхэд, аав, ээж, хадам аав, ээж, төрсөн ах эгч, дүү), жирэмсний, амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, нас барсан, нийтийг хамарсан дайчилгаанд хамрагдсан, нийтийг хамарсан аюулт халдварт өвчний улмаас хорио цээр тогтоосон бүсэд хоригдсон, галын болон байгалийн гэнэтийн аюул, эсхүл давагдашгүй хүчин зүйл (усны үер, ган, зуд, аюултай цасан болон шороон шуурга, газар хөдлөлт)-ийг;

4.31. Хүнд өвчин гэж эдгэрэхдээ удаан аминд аюултай өвчнийг.

ТАВ. ТАЛУУДЫН ЧИГ ҮҮРЭГ

5.1. Профессор, багш: Хичээлийн жилийн эхэнд А, Б, В кредитэд хамаарах ажлаа төлөвлөж бэлтгэл хангах ба улирал, хичээлийн жилийн төгсгөлд ажлын үр дүнгийн гүйцэтгэлийг тооцоолж гаргана.

5.2. Тэнхимиийн эрхлэгч: Улирлын төгсгөлд тэнхимиийн багш нарын дараагийн улиралд заах хичээлийг хуваарилж ачаалал төлөвлөх, хичээл эхлэхээс өмнө багшийн заах хичээлийн шинэчилсэн хөтөлбөрийг батлах, хичээлийн явцад хяналт тавих, зохицуулалт хийх, улирлын төгсгөлд сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ хариуцсан нэгжээс ирүүлсэн А, В ба Б кредитийн нэгтгэлийг хянаж, баталгаажуулах үүрэгтэй.

5.3. Хичээл зохицуулагч: Тэнхимээс гаргасан сургалтын ажлын ачаалал, төлөвлөлтийн дагуу хичээлийн хуваарь гаргах, сургалтын явцад хяналт тавих, зохицуулалт хийх, улирал бүр профессор, багшийн сургалтын ажлын гүйцэтгэлийг хянаж баталгаажуулах үүрэгтэй.

5.4. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгж: Профессор, багшийн сургалтын ажлын төлөвлөлтийг хянан баталгаажуулна. Улирал бүрийн төгсгөлд профессор, багшийн А кредитийн гүйцэтгэлийг хянан баталгаажуулж нэгтгэл гаргана. Хичээлийн жилийн төгсгөлд сургуулийн нийт А, Б, В кредитийн гүйцэтгэлийн нэгтгэлийг гаргана.

5.5. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн эрдэм шинжилгээ инновац хариуцсан нэгж: Улирал бүрийн төгсгөлд профессор, багшийн Б кредитийн гүйцэтгэлийг хянан баталгаажуулж нэгтгэл гаргана.

5.6. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал: Профессор, багш нарын хичээлийн жилийн нийт А, Б, В кредитэд харгалзах ажлын гүйцэтгэлийн



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06-ны өдрийн А/200 дугаар тушаалын хавсралт

нэгтгэл/үндсэн гүйцэтгэл, илүү цаг, суутгалт гэх мэт/-ийг тушаалаар баталгаажуулна.

5.7. Эрдэм шинжилгээ хариуцсан захиргааны нэгж: ШУТИС-ийн хэмжээнд Б кредитийн нэгтгэлийг гаргаж, дүн шинжилгээ хийнэ.

5.8. Сургалт хариуцсан захиргааны нэгж: ШУТИС-ийн хэмжээнд А, В кредитийн гүйцэтгэлийн нэгтгэлийг гаргаж, дүн шинжилгээ хийнэ.

5.9. ШУТИС-ийн ректорын зөвлөл: Тухайн хичээлийн жилд мөрдөх профессор, багшийн ноогдоос тусад нь тооцох, ноогдоос давуулан гүйцэтгэсэн, гэрээт багшийн сургалтын ажлыг үнэлэх 1 кредитийн үнэлгээг тогтооно. Мөн багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр үнэлэх журмын хэрэгжилт, журамд өөрчлөлт оруулах санал болон зайлшгүй шаардлагаар зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү гүйцэтгэсэн сургалтын ажлын кредитийн гүйцэтгэлд хөлс олгох эсэх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

ЗУРГАА. КРЕДИТИЙН НООГДОЛ БА ГҮЙЦЭТГЭЛ ТООЦОХ НӨХЦӨЛҮҮД

Профессор, багш ангиллын албан тушаалын кредитийн ноогдол:

6.1. ШУТИС-ийн профессор, багш нь сургалт/A/, эрдэм шинжилгээ инновац/Б/, мэргэжлийн үйлчилгээ, нийгмийн хариуцлага/B/ гэсэн 3 чиглэлийн ажил гүйцэтгэнэ.

6.2. Профессор, багшийн А, Б болон В кредитийн заавал биелүүлэх ноогдол нь нийт 20 кредит байх ба албан тушаалын зэрэглэлээс хамаарч хүснэгт 6.1-д үзүүлсэн хувь, харьцаатай байна.

Хүснэгт 6.1. Багшийн албан тушаалын зэрэглэлд харгалзах А, Б, В кредитийн ноогдол

д/д	Албан тушаал	Сургалт /A/		Эрдэм шинжилгээ, инновац /Б/		Мэргэжлийн үйлчилгээ, нийгмийн хариуцлага /В/		Нийт ноогдол кредит
		хувь	кредит	хувь	кредит	хувь	кредит	
1	Профессор	55	11	30	6	15	3	20
2	Дэд профессор	65	13	25	5	10	2	20
3	Ахлах багш	70	14	20	4	10	2	20
4	Багш	80	16	10	2	10	2	20
5	Дадлагажигч багш	85	13+4	5	1	10	2	20

Тайлбар: Профессор, багшийн А, Б, В кредитийг ердийн ажлын цаг руу шилжүүлэх үндэслэл: Нэг хичээлийн жилийн нийт ажлын цаг 20·48 цаг=960 цаг, 960 цагийг 10 хүртэл сард гүйцэтгэнэ гэвэл дунджаар нэг долоо хоногт ноогдох ердийн ажлын цаг 23.4146 цаг болно.

6.3. Профессор, багшийн А, Б, В кредитийн нэг өдрийн ноогдлыг тухайн хичээлийн жилийн ажлын өдрийн тоонд үндэслэн тодорхойлно. Сар бүрийн ажлын өдрийн тооноос хамааран тухайн сард гүйцэтгэх ноогдол ялгаатай байна. Жишээ нь тухайн хичээлийн жилийн ажлын өдрийн тоо 205 байсан гэж үзвэл 1 өдөрт ноогдох кредит 0.0976 болно. Тухайн сарын ажлын өдөр 22 хоног бол 2.1472 кредит, 23 хоног бол 2.2448 кредит гэх мэт тооцоолно. Хүснэгт 6.1-д үзүүлснээр профессорын албан тушаалын А кредитийн ноогдол 55%, Б кредитийн ноогдол 30%, В кредитийн ноогдол 15% гэвэл ажлын 22 хоногтой сард А кредит 1.18096, Б кредит 0.64416, В кредит 0.32208, нийт 2.1472 кредит болно.



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06-ны өдрийн А/200 дугаар тушаалын хавсралт

6.4. Албан тушаалын профессор, багш ангилалд хамаарах бусад албан тушаал нь хүснэгт 6.2-д үзүүлсэн заавал биелүүлэх кредитийн ноогдолтой байна.

Хүснэгт 6.2. Профессор, багш ангилалд хамаарах бусад албан тушаалын кредитийн ноогдол

д/д	Албан тушаал	Сургалт /А/	Эрдэм шинжилгээ, инновац /Б/	Мэргэжлийн үйлчилгээ, нийгмийн хариуцлага /В/	Нийт ноогдол кредит
1	Тэнхимийн эрхлэгч	7	4	9	20
2	Сургалт чанарын албаны дарга	4	-	-	4
3	Эрдэмтэн нарийн бичгийн дарга	2	2	-	4
4	Чанарын менежер	6	-	-	6

6.5. Профессор, багш ангиллын албан тушаалтны ажлын ачааллыг харгалzan дараах нөхцөлүүдэд бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын зөвлөлийн хурлын шийдвэрээр хичээлийн жилийн эхэнд А ба Б кредитийн ноогдлыг нэгээс нөгөөд шилжүүлэн тооцох нөхцөлөөр гэрээ байгуулан ажиллаж болно. Үүнд:

6.5.1. Биеийн тамир, гадаад хэл, эсвэл сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэггүй тэнхимиийн докторын зэрэггүй ахлах багш, багш нарын Б кредитийн ноогдлыг 4 хүртэлх кредитээр хорогдуулж А кредитийн ноогдлыг тэр хэмжээгээр нэмэгдүүлэн төлөвлөж болно.

6.5.2. Профессор, багш, тэнхимиийн эрхлэгч, эрдэмтэн нарийн бичгийн дарга тухайн хичээлийн жилд эрдэм шинжилгээ, инновацын ажлын кредит тооцох аргачлалын 8.1.1, 8.1.2, 8.3.3 заалтад хамаарах эрдэм шинжилгээний бүтээл туурвих нөхцөлөөр А кредитийн ноогдлоо 30 хүртэлх хувиар хорогдуулж Б кредитийн ноогдлоо тэр хэмжээгээр нэмэгдүүлэн төлөвлөж болно.

6.5.3. Профессор, багш, тэнхимиийн эрхлэгч, эрдэмтэн нарийн бичгийн дарга ШУТИС-ийн нэрийн өмнөөс олон улс, улсын хэмжээний судалгаа, инновацын төсөл удирдаж байгаа тохиолдолд А кредитийн ноогдлыг 50 хүртэлх хувиар хорогдуулж Б кредитийн ноогдлыг тэр хэмжээгээр нэмэгдүүлэн төлөвлөж болно.

6.6. ШУТИС-ийн нэрээр гаднын санхүүжилттэй судалгааны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа профессор, багш, тэнхимиийн эрхлэгч, эрдэмтэн нарийн бичгийн дарга нь албан тушаалын цалингийнхаа 50 хүртэлх хувийг төслөөсөө санхүүжүүлэх нөхцөлөөр түүнтэй дүйцэх хэмжээгээр А цагийн ноогдлоо бууруулан төлөвлөж болно. Энэ тохиолдолд бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн холбогдох тушаал гаргах ба тухайн албан тушаалд бүтэн ажилласан гэж үзнэ.

6.7. Дадлагажигч багш эхний жилд өөрийн дагалдан ажиллаж байгаа профессор, багшийн 4-өөс доошгүй кредитийн хичээлд сууж зөвлөгөө авах ба гүйцэтгэлийг хичээл заасан цагт тооцно.

6.8. Профессор, багш, тэнхимиийн эрхлэгч, сургалт чанарын албаны дарга, эрдэмтэн нарийн бичгийн дарга болон чанарын менежерийн ноогдоос давуулан зааж болох илүү кредит нь тухайн албан тушаалд харгалзах А кредитийн ноогдоос илүүгүй байна. Дадлагажигч багшид ноогдоос давсан илүү кредит заахыг зөвшөөрөхгүй. Бүтээлийн чөлөө, цалинтай чөлөө авсан, дадлагажих хөтөлбөрт хамрагдсан профессор, багшийн илүү гүйцэтгэсэн кредитийн зөвшөөрөгдөх хэмжээг үндсэн ноогдоос нь тооцно.



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06-ны өдрийн А/200 дугаар тушаалын хавсралт

6.9. Тухайн улиралд багш хүрэлцэхгүй байх мөн улирлын явцад өвчилсөн, ажлаас өөрчлөгдсөн, гадаад, дотоодод томилолтоор ажилласан багшийн хичээлийг тэнхимиин эрхлэгчийн зөвшөөрлөөр өөр багшид шилжүүлэн заалгана.

6.10. Багшлах чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, ахмад багш нарыг хөдөлмөр эрхлэх боломжоор хангах зорилгоор ШУТИС-д ажиллаж байгаад өндөр настын тэтгэвэрт гарсан, доктор (Ph.D) буюу түүнээс дээш эрдмийн зэрэгтэй, мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагатай ахмад настыг багшийн албан тушаалын "Ахлах багш" зэрэглэлд харгалзуулан дараах нөхцөлөөр үндсэн орон тоонд ажиллуулж болно. Үүнд:

6.10.1. Тухайн мэргэжлийн тэнхимиин саналыг харгалзан ахмад настын гүйцэтгэх үндсэн ноогдлыг ахлах багшийн албан тушаалын ноогдлын 50 хүртэл хувиар төлөвлөж хөдөлмөрийн хөлс, цалин, дагалдах цол, зэргийн нэмэгдлийг гүйцэтгэх кредитийн ноогдолтой хувь тэнцүүлэн олгоно.

6.10.2. Үндсэн орон тоонд ажиллах ахмад настыг ШУТИС-ийн Зөвлөх профессороор гэрээгээр давхар ажиллуулахгүй.

6.10.3. Үндсэн оронд тоонд ажиллаж байгаа ахмад настанд журмын 6.5, 6.6 заалтууд хамаарахгүй.

6.10.4. Ахмад настын гүйцэтгэх зөвшөөрөгдөх илүү кредит нь үндсэн ноогдоос хэтрэхгүй байна.

6.11. Бүтээлийн чөлөө, цалинтай чөлөө авсан, дадлагажих хөтөлбөрт хамрагдсан, мөн тухайн хичээлийн жилд албан тушаалын зэрэглэл өөрчлөгдсөн зэрэг шалтгаанаар тухайн албан тушаалд бүрэн бус хугацаагаар ажилласан албан тушаалтын кредитийн ноогдлыг 6.3 заалтад үндэслэн тооцно.

Бусад албан тушаалын кредитийн ноогдол:

6.12. ШУТИС-ийн ректор, проректор, албаны дарга, бүрэлдэхүүн, салбар сургууль, хүрээлэн, төвийн захирал нь профессорын албан тушаалын А кредитийн ноогдлын 50 хүртэлх хувьтай тэнцэх сургалтын ажлыг гэрээгээр гүйцэтгэж болно.

6.13. ШУТИС-ийн удирдах албан тушаалтан профессор, багшийн албан тушаалд хавсрсан ажиллахыг зөвшөөрөхгүй.

6.14. Магистр болон түүнээс дээш зэрэгтэй сургалтын мастер хичээлийн жилд 6 хүртэлх кредитийн лаборатори, семинар, дадлагын хичээл зааж болно.

6.15. Тухайн тэнхимд мэргэжлийн багш хүрэлцэхгүй байгаа тохиолдолд магистрт элсэн суралцаж байгаа сургалтын мастераар профессор, багшийг дагалдуулан хичээлийн жилд 4 хүртэлх кредитийн лабораторийн хичээлийг заалгаж болно. Энэ тохиолдолд заасан цагийн гүйцэтгэлээр магистрын сургалтын төлбөрөөс хөнгөлнө.

6.16. ШУТИС-ийн Ректорын тушаалаар баталсан гэрээний нөхцөлөөр зөвлөх профессорыг гэрээгээр ажиллуулж болно.

6.17. Профессор, багш хүрэлцэхгүй тохиолдолд шаардлага хангасан гэрээт багшаар улиралд 12 хүртэлх кредитийн хичээл заалгаж болно.

6.18. ШУТИС-ийн захиргааны мэргэжилтэн, бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын туслах, эрдэм шинжилгээ, инновацын ажилтан, сургалтын албаны ажилтан хичээл заахыг зөвшөөрөхгүй. Шаардлагатай тохиолдолд тэнхимиин шийдвэрийг үндэслэн 4 хүртэл кредитийн дадлага удирдах, сургалттай холбоотой бусад ажил гүйцэтгэж болно.



Кредитийн ачаалал төлөвлөх, гүйцэтгэл тооцох болон хөлс олгох нөхцөлүүд:

6.19. Профессор, багш ангиллын албан тушаалтны сургалт(А), эрдэм шинжилгээ, инновац(Б), мэргэжлийн үйлчилгээ, нийгмийн хариуцлага(В)-ын чиглэлээр гүйцэтгэх кредитийн ачаалал төлөвлөлт, гүйцэтгэлийг энэ журмын 7, 8, 9-р бүлэгт заасан аргачлалын дагуу тооцно.

6.20. Сургалтын ажлыг бүх шатны сургалтад хичээл заах, дадлага, туршилт, судалгааны ажил удирдах болон сургалттай холбоотой бусад ажил гүйцэтгэх гэж ангилах ба профессор, багш ангиллын албан тушаалтны А кредитийн үндсэн ноогдлыг хүснэгт 6.3-д үзүүлсэн хичээл заах үйл ажиллагаагаар төлөвлөнө.

6.21. Профессор, багшийн дараагийн улиралд гүйцэтгэх сургалтын ажлын төлөвлөлтийг бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалтын албанаас гаргасан 1-р хичээл сонголтын мэдээлэлд үндэслэн хуанлид заасан хугацаанд тэнхимиийн эрхлэгч гаргаж, сургалт хариуцсан нэгж баталгаажуулна.

6.22. Тэнхимиийн эрхлэгч нь профессор, багшийн сургалтын ажлын ачааллыг жигд хуваарилахаас гадна багшийн албан тушаалын зэрэглэлээс хамаарч тухайн улиралд дан бакалаврын эсвэл бакалаврын болон ахисан түвшний хөтөлбөрт хичээл заахаар ачаалал төлөвлөлт хийнэ.

6.23. Сургалтын ажлын гүйцэтгэлийг тухайн улирлын V долоо хоногийн төгсгөлд кредит баталгаажуулсан захирлын тушаалд орсон суралцагчийн тоог үндэслэн гаргана. Хүндэтгэх шалтгаанаар сургалтаас чөлөөлөгдсөн суралцагчийн тоог хасаж тооцно.

6.24. Тухайн хичээлийн жилд мөрдөх нэг кредитийн үнэлгээг Ректорын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ШУТИС-ийн Ректорын тушаалаар тогтооно. Үүнд:

6.24.1. Профессор, багш ангиллын албан тушаалтны ноогдоос давуулан гүйцэтгэсэн сургалтын ажлын 1 кредитийн үнэлгээ;

6.24.2. Профессор, багш ангиллын албан тушаалтны ноогдоос тусад нь тооцсон сургалтын ажлын 1 кредитийн үнэлгээ.

Хүснэгт 6.3. Профессор, багш ангиллын албан тушаалтны сургалтын ажлын ноогдол, үнэлгээ

д/д	Сургалтын ажил	Төрөл	Хугацаа /7 хоног/	А кредитийн үндсэн ноогдолд тооцох эсэх	1 кредитийн үнэлгээ
1	Бакалавр/ахисан түвшинд хичээл заах Танхимын(Т), Танхимын бус(Ц), Хосолсон(Т+Ц)	Үндсэн өдрийн (Т)	16/12	Тооцно	-
		Зэргийн бус (Т)	16/12	Тооцно	-
		Модуль (Т, Т+Ц)	8	Тооцно	-
		Цахим-танхим хосолсон (Т+Ц)	12	Тооцно	-
		Ганцаарчилсан (Ц, Т+Ц)	12	Тооцно	-
		Гарагийн (Т, Т+Ц)	16/12	Тооцно	-
		Эчнээ (Т)	8	А кредитийн гүйцэтгэл дутвал шилжүүлэн тооцож болно.	6.24.1 заалтаар тусад нь олгоно.
		Өвөл/зүн (Т, Ц)	4/6		
2	Дадлага, туршилт, судалгааны ажил удирдах	Цахим (Ц)	16/12 хүртэл		
		Танилцах, дипломын ёмнөх дадлага	1-3	А кредитийн гүйцэтгэл дутвал шилжүүлэн тооцож болно.	6.24.2 заалтаар тусад нь олгоно.
		Үйлдвэрлэлийн, хээрийн(Сургалтын төлөвлөгөөнд хээрийн	2-4		



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06-ны өдрийн А/200 дугаар тушаалын хавсралт

		дадлага хэлбэрээр тусгасан танилцах дадлага хамаарна) мэргэжлийн, орчуулгын дадлага		
		Магистр, докторын туршилт судалгааны ажил, мэргэжлийн магистрын хөтөлбөрийн мэргэжлийн дадлага	4-12	
3	Сургалттай холбоотой бусад ажил гүйцэтгэх	Бакалавр, магистр, докторын судалгааны ажил(дипломын төсөл, төгсөлтийн ажил, диссертаци)-тай холбоотой үйл ажиллагаа	-	А кредитийн гүйцэтгэл дутвал 6.28 заалтаар шилжүүлэн тооцож болно. 6.24.2 заалтаар тусад нь олгоно.
		Комисс бүрдүүлэн авсан шалгалтын үйл ажиллагаа	-	
		Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаа	-	

6.25. Профессор, багш ангиллын албан тушаалтан тухайн албан тушаалын ангилалд харгалзах заавал биелүүлэх кредитийн ноогдлыг бүрэн биелүүлэх үүрэгтэй бөгөөд дутуу кредитийг илүү кредитээс шилжүүлэн тооцох боломжгүй тохиолдолд тухайн албан тушаалын нэг кредитийн дундаж үнэлгээгээр үржүүлсэнтэй тэнцүү мөнгөн суутгал оноож буцаан төлүүлэх буюу ээлжийн амралтын олговроос суутгана.

6.26. Профессор, багш ангиллын албан тушаалтны Б, В кредитийн гүйцэтгэл дутсан тохиолдолд тус бүрийн ноогдлын 50 хүртэлх хувьд А кредитийн илүү гүйцэтгэлээс 1:1 харьцаагаар нөхөн тооцож болно.

6.27. Профессор, багш ангиллын албан тушаалтны А кредитийн гүйцэтгэл дутсан тохиолдолд үндсэн ноогдолд тооцоогүй хичээл заах үйл ажиллагаа болон дадлага, туршилт, судалгааны ажил удирдсан гүйцэтгэлээс дутуу кредитийн хэмжээгээр 1:1 харьцаагаар шилжүүлэн тооцно.

6.28. А кредитийн дутуу гүйцэтгэлийн 50 хүртэлх хувьд бакалаврын дипломын төсөл, магистрын төгсөлтийн ажил, докторын диссертаци удирдсан кредитийн гүйцэтгэлээс 1:1 харьцаагаар шилжүүлэн тооцно.

6.29. Бусад албан тушаалтны гүйцэтгэсэн сургалтын ажлын кредитийн хөлсийг гүйцэтгэсэн ажлын төрлөөс хамааруулж 6.24.1 эсвэл 6.24.2 заалтын дагуу тооцож олгоно.

6.30. Гаднын байгууллагаас дадлага, туршилт, судалгааны ажил удирдсан, сургалттай холбоотой бусад ажил гүйцэтгэсэн, урилгаар нэг удаагийн лекц уншсан бол кредитийн хөлсийг гүйцэтгэсэн ажлын төрлөөс хамааруулж 6.24.1 эсвэл 6.24.2 заалтын дагуу тооцож олгоно.

6.31. Профессор, багш 8.1.1, 8.1.2, 8.3.3 заалтын аль нэгд хамаарах эрдэм шинжилгээ, инновацийн ажлыг оролцуулан Б кредитийн ноогдоо давуулан биелүүлсэн тохиолдолд албан тушаалын Б кредитийн ноогдлын 50 хүртэл хувьтай тэнцэх кредитэд 6.24.1 заалтын дагуу хөлс тооцож олгоно.

6.32. Биеийн тамирын багшийн хариуцан хичээллүүлэх ШУТИС-ийн шигшээ багийн бэлтгэл сургалтын нийт цаг нь улиралд 64 цагаас хэтрэхгүй байх



ШУТИС-ийн ректорын 2025.оны 06 дугаар сарын
06-ны өдрийн А/200 дугаар тушаалын хавсралт

ба гүйцэтгэсэн цагийн 50 хүртэлх хувьд харгалзах кредитийн хөлсийг 6.24.2 заалтын дагуу тооцож олгоно.

6.33. Эмнэлгийн магадалгаагаар хүнд өвчний дараах эмчилгээ хийлгэж байгаа профессор, багш ангиллын албан тушаалтны хүснэгтийг харгалзан бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын зөвлөлийн хурлын шийдвэрээр тухайн хичээлийн жилийн Б, В цагийн ачааллыг бүрэн хөнгөлж болно.

6.34. Профессор, багш ангиллын албан тушаалтны хичээлийн жилийн кредитийн гүйцэтгэлийг урьдчилан тооцож, боломжтой гэж үзвэл бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгжийн шийдвэрээр эхний улирлын эцэст гүйцэтгэсэн илүү кредитийн хөлсний тодорхой хэсгийг урьдчилж олгож болно.

6.35. Профессор, багш тухайн хуваарьт цагийн хичээлийг тасалсан тохиолдолд холбогдох тушаал шийдвэрийн дагуу суутгал тооцох ба тухайн тасалсан цагийн хичээлийг агуулгаар нь заавал нөхөж орсон байна.

ДОЛОО. СУРГАЛТЫН АЖЛЫН КРЕДИТИЙН ТООЦОО

7.1. ШУТИС-ийн профессор, багшийн гүйцэтгэх сургалтын ажлын кредитийг дараах ангиллын дагуу тохирох аргачлалаар тооцно. Үүнд:

- 7.1.1. Хичээл заасан кредит
- 7.1.2. Дадлага, туршилт судалгааны ажил удирдсан кредит
- 7.1.3. Сургалттай холбоотой бусад ажлын кредит

Хичээл заасан кредит тооцох:

7.2. Бүх түвшний сургалтад 30 хүртэлх суралцагчтай хичээлийн 1 кредит буюу 48 цагийн хөдөлмөрт дараах үйл ажиллагаа багтсан байна. Үүнд:

7.2.1. Сургалтад бэлтгэх: Хичээлийн хөтөлбөр боловсруулах, сургалтын материал, цахим сургалтын хэрэглэгдэхүүн, бие даалт, явцын сорил, тест, улирлын шалгалтын материал бэлтгэх гэх мэт.

7.2.2. Хичээл удирдан явуулах: Танхим, танхимиын бус, хосолсон хэлбэрээр бакалавр, магистр, докторын түвшинд хичээлийг хөтлөн явуулах үйл ажиллагааг хэлнэ.

7.2.3. Суралцагчдын мэдлэг, чадварыг үнэлэх: Суралцагчид зөвлөгөө өгөх, явцын болон улирлын шалгалт, бусад хэлбэрээр суралцагчдын мэдлэг чадварыг үнэлэх (реферат, тайлан, гэрийн даалгавар, бие даалт шалгах гэх мэт).

7.3. Хөтөлбөрийн түвшнээс хамаарч хичээлийн хэлбэрт харгалзах 1 кредит нь хүснэгт 7.1-д үзүүлсэн цагийн хуваарилалттай байна. Хичээлийн тухайн хэлбэрт харгалзах кредитийн гүйцэтгэлийг тооцоходоо хичээл удирдан явуулсан цагийн гүйцэтгэлд үндэслэнэ.

Хүснэгт 7.1. Хичээлийн 1 кредит цагийн хуваарилалт

д/д	Хичээлийн хэлбэр	Сургалтад бэлтгэх	Хичээл удирдан явуулах	Суралцагчтай ажиллах /зөвлөх, мэдлэг, чадварыг үнэлэх/	Нийт цаг
Дэд бакалавр, бакалавр					
1	Лекц	12 цаг	16 цаг	20 цаг	48 цаг
2	Семинар, лаборатори, практик	8 цаг	32 цаг	8 цаг	48 цаг
Магистр, доктор					
3	Лекц	14 цаг	12 цаг	22 цаг	48 цаг
4	Семинар, лаборатори, практик	10 цаг	24 цаг	14 цаг	48 цаг



ШУТЫС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06-ны өдрийн А/200 дугаар тушаалын хавсралт

7.4. Бүх түвшний сургалтад тухайн хичээлийн суралцагчийн тоо 1-15 байх тохиолдолд хичээлийн кредитийн гүйцэтгэлийг (1) томьёогоор бодно.

$$Ch = (ch_{\text{лекц}} + ch_{\text{сем}} + ch_{\text{лаб}} + ch_{\text{пр}}) \cdot d \cdot \frac{N}{15} + \alpha \quad (1)$$

Энд:

Ch - Тухайн хичээлээс багшид тооцох нийт кредит;

N - Хичээл сонгосон суралцагчийн тоо;

$Ch_{\text{лекц}}$ - Хичээлийн лекцээс багшид тооцсон кредит;

$Ch_{\text{сем}}$ - Хичээлийн семинараас багшид тооцсон кредит;

$Ch_{\text{лаб}}$ - Хичээлийн лабораториос багшид тооцсон кредит;

$ch_{\text{пр}}$ - Хичээлийн практикаас багшид тооцсон кредит;

d - Хичээлийн түвшинд харгалзах итгэлцүүр;

- Ерөнхий суурийн хичээл $d = 1.0$
- Мэргэжлийн суурь хичээл $d = 1.0$
- Мэргэшүүлэх хичээл $d = 1.2$
- Ахисан түвшний хичээл $d = 1.4$

α - тэнцвэржүүлэх коэффициент бөгөөд тухайн хичээлийн суралцагчийн тоо ба лекцээс багшид тооцсон кредитээс хамааруулж (2) томьёогоор бодно.

$$\alpha = (15 - N) \cdot 0.03 \cdot ch_{\text{лекц}} \quad (2)$$

Энд:

$Ch_{\text{лекц}}$ - Хичээлийн лекцээс багшид тооцсон кредит;

N - Хичээл сонгосон суралцагчийн тоо;

7.5. Бүх түвшний сургалтад тухайн хичээлийн суралцагчийн тоо 16-30 байх тохиолдолд хичээлийн кредитийн гүйцэтгэлийг (3) томьёогоор бодно.

$$Ch = (ch_{\text{лекц}} + ch_{\text{сем}} + ch_{\text{лаб}} + ch_{\text{пр}}) \cdot d \quad (3)$$

Энд:

Ch - Тухайн хичээлээс багшид тооцох нийт кредит;

$Ch_{\text{лекц}}$ - Хичээлийн лекцээс багшид тооцсон кредит;

$Ch_{\text{сем}}$ - Хичээлийн семинараас багшид тооцсон кредит;

$Ch_{\text{лаб}}$ - Хичээлийн лабораториос багшид тооцсон кредит;

$ch_{\text{пр}}$ - Хичээлийн практикаас багшид тооцсон кредит;

d - Хичээлийн түвшинд харгалзах итгэлцүүр;

- Ерөнхий суурийн хичээл $d = 1.0$
- Мэргэжлийн суурь хичээл $d = 1.0$
- Мэргэшүүлэх хичээл $d = 1.2$
- Ахисан түвшний хичээл $d = 1.4$

7.6. Бүх түвшний сургалтад тухайн хичээлийн суралцагчийн тоо 31 ба түүнээс их үед суралцагчтай ажилласан цагийг нэмэлтээр тооцож кредитийн гүйцэтгэлийг (4) томьёогоор бодно.

$$Ch = (ch_{\text{лекц}} + ch_{\text{сем}} + ch_{\text{лаб}} + ch_{\text{пр}}) \cdot d + Ch_{\text{бд}} \quad (4)$$



Энд:

Ch - Тухайн хичээлээс багшид тооцох нийт кредит;

$Ch_{\text{лекц}}$ - Хичээлийн лекцээс багшид тооцсон кредит;

$Ch_{\text{сем}}$ - Хичээлийн семинараас багшид тооцсон кредит;

$Ch_{\text{лаб}}$ - Хичээлийн лабораториос багшид тооцсон кредит;

$ch_{\text{пр}}$ - Хичээлийн практикаас багшид тооцсон кредит;

d - Хичээлийн түвшинд харгалзах итгэлцүүр:

- Ерөнхий суурийн хичээл $d = 1.0$
- Мэргэжлийн суурь хичээл $d = 1.0$
- Мэргэшүүлэх хичээл $d = 1.2$
- Ахисан түвшний хичээл $d = 1.4$

Суралцагчийн бие даалтын даалгаврыг үнэлэх, зөвлөгөө өгөхөд зориулж тухайн хичээлийн лекцийн 1 кредит тутамд, 30-аас давсан суралцагч бүрд багшид нэмэлтээр тооцох кредитийг (5) томьёогоор бодно.

$$Ch_{\text{бд}} = \sum_{i=1}^n (N_i - 30) \cdot 0.008 \cdot ch_{\text{лекц},i} \quad (5)$$

Энд:

$Ch_{\text{лекц},i}$ - Хичээлийн i -р лекцээс багшид тооцсон кредит;

N_i - Хичээлийн i -р лекцийг сонгосон суралцагчийн тоо.

7.7. Хичээлийн бүлгийг анги танхим, лабораторийн багтаамж, хүчин чадлыг бүрэн ашиглахуйц хэмжээгээр буюу семинарын хэлбэрт 30-44 хүртэл, практикийн хэлбэрт 24-34 хүртэл, лабораторийн хэлбэрт 20-24 хүртэл оюутантайгаар зохион байгуулна. Компьютер ашиглан зохион байгуулдаг лабораторийн багтаамж, компьютерын тоог харгалзан 44 хүртэл суралцагчтайгаар хичээллүүлж болно.

7.8. Хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай нөхцөл шаардах тоног төхөөрөмж бүхий бакалаврын сургалтын зарим мэргэжлийн хичээлийн лабораторийн бүлгийг тухайн сургуулийн захирлын зөвлөлийн хурлын саналыг үндэслэн сургалт хариуцсан захиргааны нэгжийн шийдвэрээр 20-аас доош оюутантай тогтоож болно.

7.9. Биеийн тамирын танхимиын сургалтын хичээлийн бүлгийг 30-40 хүртэл, танхимаас гадуур сургалт(спорт аялал)-ын хичээлийн бүлгийг 60-аас доошгүй оюутантайгаар зохион байгуулах ба багшид тооцох кредитийг 60 оюутан тутамд 1 кредит байхаар тооцоолно.

7.10. Сургалт хариуцсан захиргааны нэгжээс гаргасан удирдамжийн дагуу дараах нөхцөлүүдээр профессор, багшийн заасан хичээлийг үнэлж, кредитийн гүйцэтгэлийг нэмэгдүүлэн хичээлийн жилд нэг удаа тооцож болно. Үүнд:

7.10.1. Тухайн сургалтын хөтөлбөрийн мэргэжлийн суурь, мэргэшүүлэх түвшний шинэ хичээлийн сургалтын материалыг анх удаа бүрэн бэлтгэж, заасан бол тухайн хичээлийн кредитийн гүйцэтгэлийг 20 хүртэл хувиар нэмэгдүүлэн тооцно.

7.10.2. Бүх түвшний сургалтын хөтөлбөрийн хэлний мэргэжлийн бус хичээлийг гадаадын аль нэг хэл дээр бүрэн боловсруулж, заасан тохиолдолд тухайн хичээлийн кредитийн гүйцэтгэлийг 50 хүртэл хувиар нэмэгдүүлэн тооцно.

7.10.3. Сургалтын дэвшилтээ технологи, идэвхтэй сургалтын аргазүй, ашиглан тусгай хуваарийн дагуу суралцагч, багш наарт зориулж нээлттэй хичээл зохион байгуулсан бол хичээлийн 2 цаг тутамд 0.03 хүртэл кредит нэмж тооцно.

7.10.4. Профессор, багшийн тухайн улиралд заасан хичээлийн суралцахуйн үр дүнгийн тайлан, суралцагчийн сэтгэл хамамжийн санал асуулгад үндэслэн тэнхимиийн хамгийн өндөр гүйцэтгэл бүхий нэг профессор, багшийн тухайн хичээлийн кредитийн гүйцэтгэлийг 10 хүртэл хувиар нэмэгдүүлэн тооцно.

7.10.5. Цахим хичээлд тавих шаардлагад нийцүүлэн бүрэн цахим хичээл боловсруулж, тухайн улиралд цахим сургалт зохион байгуулсан бол профессор багшийн тухайн хичээлийн кредитийн гүйцэтгэлийг 20 хүртэл хувиар нэмэгдүүлэн тооцно.

7.11. Өвөл, зуны сургалтыг танхим, танхимиын бус хэлбэрээр зохион байгуулах ба сургалтад хичээл заасан багшид тооцох кредитийг суралцагчийн тооноос хамааруулж (1), (3) эсвэл (4) томьёогоор бодно.

7.12. Эчнээ, гарагийн, ганцаарчилсан сургалтыг танхим, танхимиын бус, хосолсон хэлбэрээр зохион байгуулах ба сургалтад хичээл заасан багшид тооцох кредитийг суралцагчийн тооноос хамааруулж (1), (3) эсвэл (4) томьёогоор бодно.

7.13. Суралцагч асуудал шийдвэрлэх даалгавар гүйцэтгэн хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагаа практик хэрэглээ болгоход чиглэсэн, сургалтын төлөвлөгөөнд тусдаа тусгагдсан төслийн хичээлийг практикийн хичээл хэлбэрээр төлөвлөн хичээлийн хуваарьт тусгаж, багшид тооцох кредитийг суралцагчийн тооноос хамааруулж (1), (3) эсвэл (4) томьёогоор бодно.

Дадлага, туршилт, судалгааны ажлын кредит тооцох:

7.14. Бакалаврын сургалтын хөтөлбөрт ажлын байранд суурилсан сургалт хэлбэрээр 20 хүртэл кредитийн дадлагын хичээл тусгаж болох ба агуулгын багтаамжаас хамааруулан 4 хүртэл кредиттэй, курс ахих тусам гүнзгийрүүлэн судлах хэд хэдэн хичээл байдлаар төлөвлөнө.

7.15. Дадлагын 1 кредит нь ажлын байранд эсвэл сургууль дээр лаборатори, практик, дадлагын орчинд суралцах 32 цаг, бие даан суралцах 16 цагаас бүрдэнэ. Суралцагч өдөрт 4-өөс доошгүй цаг дадлагын орчинд, 2 цаг бие даан суралцана гэж үзэж дадлагын үргэлжлэх хугацааг тогтооно.

7.16. Дадлагын төрөл, онцлогоос хамаарч нь зөвхөн сургууль талаас багш дангаар удирдах, эсвэл үйлдвэр талын удирдагчтай хамтран удирдаж болно. Хамтран удирдсан тохиолдолд ажлын гүйцэтгэлийг харгалзан тэнхимиийн саналаар гүйцэтгэсэн кредитийг удирдагч багш ба үйлдвэрийн талын удирдагчид хувааж олгоно.

7.17. Дадлагыг тусгай удирдамжийн дагуу зохион байгуулах ба 30 хүртэлх оюутантай бүлэг бүрд сургууль талаас 1 удирдагч багш томилон ажиллуулна.

7.18. Танилцах болон дипломын өмнөх дадлагад сургууль талаас удирдагч багшийг томилох ба багшид тооцох кредитийг (6) томьёогоор бодно.

$$Ch_{t,\text{дө}} = 0.02 \cdot C_K \cdot N \quad (6)$$

Энд:

C_K - Тухайн дадлагад харгалзах сургалтын төлөвлөгөөнд туссан кредит

N - Дадлага хийсэн оюутны тоо

$Ch_{t,\text{дө}}$ -Танилцах болон дипломын өмнөх дадлагаар гүйцэтгэсэн нийт кредит

7.19. Бакалаврын хөтөлбөрийн үйлдвэрлэлийн, хээрийн(Сургалтын төлөвлөгөөнд хээрийн дадлага хэлбэрээр тусгасан танилцах дадлага хамаарна) мэргэжлийн, орчуулгын дадлага болон магистр, докторын туршилт судалгааны



ШУТИСийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06-ны өдрийн А/200 дугаар тушаалын хавсралт

ажил, мэргэжлийн магистрын хөтөлбөрийн мэргэжлийн дадлагын удирдагч багшид тооцох кредитийг (7) томьёогоор бодно.

$$Ch_{y_d, tca} = 0.06 \cdot C_K \cdot N \quad (7)$$

Энд:

C_K - Тухайн дадлага, туршилт судалгааны ажилд харгалзах сургалтын төлөвлөгөөнд туссан кредит

N - Хамрагдсан суралцагчийн тоо

$Ch_{y_d, tca}$ - Үйлдвэрлэлийн болон түүнтэй төстэй дадлага болон ахисан түвшний туршилт, судалгааны ажлаар гүйцэтгэсэн кредит

Сургалттай холбоотой бусад ажлын кредит тооцох:

7.20. Багшийн гүйцэтгэсэн сургалттай холбоотой бусад ажлыг кредитээр үнэлж багшийн үндсэн ноогдолд оруулахгүйгээр тусад нь тооцно.

7.21. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын зөвлөлийн хурлын шийдвэрийн үндэслэн гадаадад хөтөлбөр магадлан итгэмжлүүлсэн өөрийн үнэлгээний багт 15, дотоодод хөтөлбөр магадлан итгэмжлүүлсэн өөрийн үнэлгээний багт 10 хүртэл кредит тооцож олгоно.

7.22. Бакалавр, магистрын, докторын сургалтад комисс бүрдүүлэн шалгалт зохион байгуулсан бол хүснэгт 7.3-д заасан жишгээр кредит тооцно.

Хүснэгт 7.3. Шалгалттай холбоотой бусад ажлын кредит

д/д	Шалгалтын төрөл	Хэмжих нэгж	Тооцох кредит
1	Бүх шатны сургалтын шалгалт зохион байгуулах комиссын гишүүн	Шалгуулагч бүрд	0.002
2	Комиссын бүрэлдэхүүнтэй авах тестийн шалгалтын материал боловсруулах	2-оос доошгүй хувилбартай шалгалтын тест бүрд	0.08

7.23. Бакалавр, магистр, докторын төгсөлттэй холбоотой сургалтын ажлын кредитийн гүйцэтгэлийг хөтөлбөрийн түвшнээс хамаарч хүснэгт 7.4-өөс хүснэгт 7.6-д үзүүлсэн аргачлалаар тооцно.

7.24. Тэнхимийн профессор, багшийн ажлын ачаалал, албан тушаалын зэрэглэл болон тухайн улиралд төгсөх оюутан, магистрантын тоог тус тус харгалzan тухайн багшийн удирдах бакалаврын дипломын төсөл, магистрын төгсөлтийн ажлын тоог тэнхимийн хурлын шийдвэрээр тогтооно.



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06-ны өдрийн А/200 дугаар тушаалын хавсралт

Хүснэгт 7.4. Бакалаврын төгсөлттэй холбоотой ажлын кредит

д/д	Үйл ажиллагааны төрөл	Хэмжих нэгж	Тооцох кредит
1	Бакалаврын дипломын төсөл удирдах	1 сэдвэр 1 оюутан	0.4
		1 сэдвэр 2 оюутан	0.65
		1 сэдвэр 3 оюутан	0.9
2	Бакалаврын дипломын төсөлд зөвлөхөөр ажиллах (Дипломын төсөлд 2 хүртэл зөвлөх томилж болох ба ноогдох кредитийг зөвлөхүүдэд хувааж олгоно)	1 төсөл	0.04
3	Урьдчилсан шалгалт болон урьдчилсан хамгаалалтын комисст ажиллах (Төгсөлтийн салбар комиссын сургууль талын бүрэлдэхүүн ажиллана)	1 оюутан	0.02
4	Төгсөлтийн салбар комиссын нарийн бичгийн даргаар ажиллах	1 оюутан	0.05
5	Бакалаврын дипломын төсөлд шүүмж бичих (Дипломын ажлын онцлогоос хамаарч шүүмжлэгч томилохгүй байж болно)	1 төсөл	0.03
6	Бакалаврын жинхэнэ хамгаалалт, төгсөлтийн шалгалтын комисст ажиллах (Төгсөлтийн салбар комисс ажиллана)	1 оюутан	0.02
7	Төгсөлтийн шалгалт өгөх оюутнуудад тодорхой сэдвэр давтлага өгөх (Төгсөлтийн шалгалтын асуултын багцад байгаа тухайн хичээлээр 2 хүртэл цагийн давтлага өгч болно)	2 цаг	0.04

Хүснэгт 7.5. Магистрын төгсөлттэй холбоотой ажлын кредит

д/д	Үйл ажиллагааны төрөл	Хэмжих нэгж	Тооцох кредит
1	Магистрын төгсөлтийн ажил удирдах (Салбар дундын судалгааны ажил 2 хүртэл удирдагчтай байж болно. Ноогдох кредитийг удирдагчийн тоонд хувааж олгоно)	1 төгсөлтийн ажил	0.7
2	Магистрын төгсөлтийн ажилд зөвлөхөөр ажиллах (Ноогдох кредитийг зөвлөхүүдэд хувааж олгоно)	1 төгсөлтийн ажил	0.16
3	Магистрын урьдчилсан хамгаалалтын комисст ажиллах	1 магистрант	0.03
4	Хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллах	1 магистрант	0.05
5	Хамгаалуулах зөвлөлийн гишүүнээр ажиллах	1 магистрант	0.03
6	Магистрын төгсөлтийн ажилд шүүмж бичих	1 төгсөлтийн ажил	0.06
7	Мэргэжлийн магистрын нэгдсэн шалгалт авах (Мэргэжлийн магистрын хөтөлбөрт)	Гишүүн бүрд	0.03



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06-ны өдрийн А/200 дугаар тушаалын хавсралт

Хүснэгт 7.6. Докторын төгсөлттэй холбоотой ажлын кредит

д/д	Үйл ажиллагааны төрөл	Хэмжих нэгж	Тооцох кредит
1	Докторын диссертаци удиরдах	Удирдагч бүрд TTA11614 9087087	2
2	Докторын диссертацид зөвлөхөөр ажиллах	Зөвлөх бүрд	0.4
3	Докторын диссертацид шүүмж бичих	Шүүмжлэгч бүрд	0.4
4	Дэд зөвлөлийн даргаар ажиллах (Урьдчилсан болон жинхэнэ хамгаалалт)	Бүтээл бүрд	0.5
5	Дэд зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллах (Урьдчилсан болон жинхэнэ хамгаалалт)	Бүтээл бүрд	0.5
6	Дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллах (Урьдчилсан болон жинхэнэ хамгаалалт)	Гишүүн бүрд	0.2
7	Докторантаас мэргэжлийн нэгдсэн шалгалт авах	Гишүүн бүрд	0.2



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06-ны өдрийн А/200 дугаар тушаалын хавсралт

НАЙМ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦЫН АЖЛЫН КРЕДИТИЙН ТООЦОО

Эрдэм шинжилгээ, инновацын ажлын кредитийг дараах байдлаар тооцно.

8.1. Олон улсад хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл ба олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд хэвлүүлсэн өгүүлэл болон илтгэлд дараах кредит тооцно.

Хүснэгт 8.1. Олон улсад хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл, илтгэл

д/д	Бүтээлийн төрөл	Хэмжих нэгж	Кредит	Тайлбар
8.1.1	Олон улсын мэдээллийн санд (Web of Science, SCOPUS) бүртгэлтэй сэтгүүлд ШУТИС-ийн нэр дээр хэвлэгдсэн өгүүлэл (article): - Нэгдүгээр зохиогч, холбоо барих зохиогч* - Бусад хамтран зохиогч	1 өгүүлэл	6 3	Нэгдүгээр зохиогч, холбоо барих зохиогч* тус бүрд харгалзах кредитийг бүрэн олгоно. Бусад хамтран зохиогчид харгалзах кредитийг тэнцүү хувааж олгоно
8.1.2	Олон улсын мэдээллийн санд (Web of Science, SCOPUS)-д бүртгэгдсэн, ШУТИС-ийн нэр дээр бичигдсэн өгүүлэл (article)-ээс бусад бүтээлийн зохиогч тус бүрд кредитийг хуваахгүйгээр бүтэн тооцно. - Нэгдүгээр зохиогч, холбоо барих зохиогч - Бусад хамтран зохиогч	1 бүтээл	5 2.5	Номын хувьд нэг бүлгийг 1 бүтээл гэж тооцно.
8.1.3	Олон улсын мэдээллийн сан (Web of Science, SCOPUS)-д бүртгэлгүй боловч мэргэжлийн түвшинд хянагддаг (Dimensions-д бүртгэлтэй), ШУТИС-ийн нэр дээр хэвлэгдсэн бүтээл: - Нэгдүгээр зохиогч, холбоо барих зохиогч - Бусад хамтран зохиогч	1 өгүүлэл /бүтээл	4 2	Нэгдүгээр зохиогч, холбоо барих зохиогч* тус бүрд харгалзах кредитийг бүрэн олгоно. Бусад хамтран зохиогчид харгалзах кредитийг тэнцүү хувааж олгоно
8.1.4	Олон улсын хурлын ¹ эмхэтгэлд нэгдүгээр зохиогч, холбоо барих зохиогчоор өгүүлэл хэвлүүлэх: - Бүрэн хэмжээний өгүүлэл - Өгүүллийн хураангуй	1 өгүүлэл	2 1	Нэгдүгээр зохиогч, холбоо барих зохиогч* тус бүрд харгалзах кредитийг бүрэн олгоно. Бусад хамтран зохиогчид харгалзах кредитийг тэнцүү хувааж олгоно ШУТИС-ийн нэр дээр хэвлэгдсэн байна.
8.1.5	Олон улсын хэмжээний хуралд илтгэл хэлэлцүүлэх: - Аман илтгэл - Ханан илтгэл (poster)	1 илтгэл	1 0.5	Зөвхөн 1 илтгэгчид кредит тооцно. Ханан илтгэлийн хувьд нэгдүгээр зохиогчийн саналаар 0.5 кредитийг хувааж олгоно. ШУТИС-ийн нэр дээр хэвлэгдсэн байна.

¹ З-аас доошгүй улсын судлаачид оролцсон, З-аас доошгүй сарын өмнө зарлагдсан (call paper) эрдэм шинжилгээний хурлыг олон улсын хуралд тооцно. 2 ба түүнээс доош орны төлөөлөлтэй бол дотоодын эрдэм шинжилгээний хуралд тооцно.



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06-ны өдрийн А/200 дугаар тушаалын хавсралт

8.2. Дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэгдсэн өгүүлэл, дотоодод зохиогдсон эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд хэвлүүлсэн өгүүлэл болон илтгэл дараах кредит тооцно.

**Хүснэгт 8.2. Дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлийн өгүүлэл,
хурлын эмхэтгэлийн өгүүлэл, илтгэл**

Д/д	Бүтээлийн төрөл	Хэмжих нэгж	Кредит	Тайлбар
8.2.1	ШУТИС-ийн ректорын тушаалаар батлагдсан эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалтад орсон сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх: - Нэгдүгээр зохиогч, холбоо барих зохиогч - Бусад хамтран зохиогч.	1 өгүүлэл	1.2 1.2	Нэгдүгээр зохиогч, холбоо барих зохиогч* тус бүрд харгалзах кредитийг бүрэн олгоно. Бусад хамтран зохиогчид харгалзах кредитийг тэнцүү хувааж олгоно
8.2.2	Редакцын зөвлөл нь олон улсын эрдэмтдээс бүрдсэн гадаад хэл дээр хэвлэгддэг эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх: - Нэгдүгээр зохиогч, холбоо барих зохиогч - Бусад хамтран зохиогч	1 өгүүлэл	2 2	ШУТИС-ийн ректорын тушаалаар батлагдсан эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалтад орсон сэтгүүлд хамаарна.
8.2.3	Улсын хэмжээний ² ЭШХ-ын эмхэтгэлд өгүүлэл хэвлүүлэх: - Бүрэн хэмжээний өгүүлэл - Өгүүллийн хураангуй	1 өгүүлэл	1 0.5	Нэгдүгээр зохиогч, холбоо барих зохиогч* тус бүрд харгалзах кредитийг бүрэн олгоно.
8.2.4	Их сургуулийн хэмжээний ЭШХ-ын эмхэтгэлд өгүүлэл хэвлүүлэх: - Бүрэн хэмжээний өгүүлэл - Өгүүллийн хураангуй	1 өгүүлэл	0.5 0.3	Бусад хамтран зохиогчдод ноогдсон кредитийг тэнцүү хуваана.
8.2.5	Улсын хэмжээний ЭШХ-ын илтгэл хэлэлцүүлэх: - Аман илтгэл - Ханан илтгэл (poster)	1 илтгэл	0.5 0.3	Зөвхөн 1 илтгэгчид кредит тооцно. Ханан илтгэлийн хувьд нэгдүгээр зохиогчийн саналаар 0.3 кредитийг хувааж олгоно. ШУТИС-ийн нэр дээр хэвлэгдсэн байна.

² З-аас доошгүй байгууллага оролцсон, З-аас доошгүй сарын өмнө зарлагдсан (call paper) эрдэм шинжилгээний хурлыг улсын хэмжээний хурал гэж тооцно.

* Холбоо барих зохиогч гэж өгүүлэл дээр тусгайлан тэмдэглэгдсэн (*, # гэх мэт) нэг зохиогчийг хэлнэ. Нэгдүгээр зохиогч болон холбоо барих зохиогчоор нэг хүн байгаа тохиолдолд кредитийг давхардуулж олгохгүй.



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06-ны өдрийн А/200 дугаар тушаалын хавсралт

8.3. Эрдэм шинжилгээний бүтээлд дараах кредит тооцно.

Хүснэгт 8.3. Эрдэм шинжилгээний бүтээл

д/д	Бүтээлийн төрөл	Хэмжих нэгж	Кредит	Тайлбар
8.3.1	Монгол хэл дээр хэвлүүлсэн нэг сэдэвт бүтээл (монограф)	1 х.х.	0.3	8.3.3-тай давхардуулж тооцохгүй. Эрдмийн зөвлөлөөр дэмжигдсэн бөгөөд диссертацийн агуулгатай 70 хувь хүртэл давхцаж болно. Кредит тус бүрийг зохиогчийн оролцоогоор хувааж олгоно.
8.3.2	Гадаад хэл дээр бичигдсэн нэг сэдэвт бүтээл (монограф)	1 х.х.	0.5	8.1.1, 8.3.3-тай давхардуулж тооцохгүй. Диссертацийн агуулгатай 70 хувь хүртэл давхцаж болно. Кредит тус бүрийг зохиогчийн оролцоогоор хувааж олгоно.
8.3.3	Эрдмийн зэрэг хамгаалсан диссертацийн ажил: - Sc.D болон Ph.D-ын диссертаци	1 ажил	5	
8.3.4	Сурах бичиг (ШУТИС-ийн Үндсэн сурах бичиг): - Анхны хэвлэлт - Дахин хэвлэлт	1 х.х.	0.6 0.4	"ШУТИС-ийн профессор, багш нарын ном, сурах бичиг, сургалтын материал бичиж хэвлүүлэхэд баримтлах журам"-ын шаардлагыг хангасан байна. Кредит тус бүрийг зохиогчийн оролцоогоор хувааж олгоно.
8.3.5	Орчуулгын бүтээл (ШУТИС-ийн захиалгат, зохиогчийн зөвшөөрөлтэй)	1 х.х.	0.3	Ном сурах бичгийн зөвлөл эсвэл бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн байна. Кредит тус бүрийг зохиогчийн оролцоогоор хувааж олгоно.
8.3.6	Гарын авлага (лабораторийн заавар, дасгал ажлыг тооцохгүй): - Анхны хэвлэлт - Дахин хэвлэлт	1 х.х.	0.2 0.1	"ШУТИС-ийн профессор, багш нарын ном, сурах бичиг, сургалтын материал бичиж хэвлүүлэхэд баримтлах журам"-ын шаардлагыг хангасан байна.
8.3.7	Толь бичиг, Мэргэжлийн лавлах: - Анхны хэвлэлт - Дахин хэвлэлт	1 х.х.	0.2 0.1	Кредит тус бүрийг зохиогчийн оролцоогоор хувааж олгоно.
8.3.8	WoS, SCOPUS-т эшлэгдсэн бүтээл: (ШУТИС-ийн нэр дээр хэвлэгдсэн өгүүлэл) - Нэгдүгээр зохиогч, холбоо барих зохиогч - Бусад хамтран зохиогч	1 эшлэл	0.5 0.1	WoS, SCOPUS-т зөвхөн тухайн онд эшлэгдсэн тоогоор зохиогч тус бүрд тооцно.
8.3.9	Бие даасан үзэсгэлэн гаргаж, каталог хэвлүүлсэн: - Каталог (альбом)	1 х.х.	0.27	A4-ээс багагүй хэмжээтэй 11-ээс цөөнгүй нүүр бүхий каталог хэвлэгдэн гарсан бол тооцно. Оролцогч бүрд оролцоогоор нь хувилж тооцно (Дизайны багш нарт хамаарна)

8.4. Оюуны өмч, инновацын үйл ажиллагаанд дараах кредит тооцно.

Хүснэгт 8.4. Оюуны өмч, инновацын үйл ажиллагаа

д/д	Бүтээлийн төрөл	Хэмжих нэгж	Кредит	Тайлбар
8.4.1	Шинэ бүтээлийн патент: - Гадаадад - Дотоодод	1 патент	5 4	ШУТИС-ийн эзэмшилтэй шинэ бүтээлийн патентыг тооцох бөгөөд зохиогч тус бүрд кредитийг бүтэн тооцно.
8.4.2	Ашигтай загвар: - Гадаадад - Дотоодод	1 ашигтай загварын патент	3 2	ШУТИС-ийн эзэмшилтэй ашигтай загварын патентыг тооцох бөгөөд зохиогч тус бүрд кредитийг бүтэн тооцно.
8.4.3	Бүтээгдэхүүний загвар: - Гадаадад - Дотоодод	1 бүтээгдэхүүний загварын патент	3 1	ШУТИС-ийн эзэмшилтэй бүтээгдэхүүний загварын патентыг тооцох бөгөөд зохиогч тус бүрд кредитийг бүтэн тооцно.
8.4.4	Барааны тэмдэгт: - Гадаадад - Дотоодод	1 барааны тэмдэгт	2 1	ШУТИС-ийн эзэмшилтэй барааны тэмдгийг тооцох бөгөөд зохиогч тус бүрд кредитийг хувааж тооцно.
8.4.5	Зохиогчийн авсан бүтээл эрх	1 зохиогчийн эрхийн гэрчилгээ	1	ШУТИС-ийн эзэмшилтэй зохиогчийн эрхийг тооцох бөгөөд компьютерын программаас бусад төрлийн зохиогчийн эрхийг зохиогч наарт тэнцүү хувааж кредит олгоно. Зохиогчийн эрхийн бүтээл нь тухайн хичээлийн жилд зохиогдож гэрчилгээ авсан буюу нийтийн хүртээл болсон бүтээл байна.
8.4.6	Инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээ	1 бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээ	1	Инновацын тухай хуулийн 15.1-г хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээ байх ба зохиогч тус бүрд кредитийг бүтэн тооцно.
8.4.7	Инновацын бүтээлийн үзэсгэлэн: - Гадаадад - Дотоодод	1 үзэсгэлэн	1 0.5	Инновацын бүтээлийн үзэсгэлэн нь улсын болон их сургуулийн хэмжээний үзэсгэлэн байна. Үзэсгэлэнгийн удирдамж, инновац хариуцсан нэгжийн тодорхойлолтыг үндэслэнэ. Үзэсгэлэнд бүтээлээ олон нийтэд танилцуулсан зөвхөн нэг зохиогчид кредитийг бүтэн тооцно.
8.4.8	Лиценз, технологи дамжуулах гэрээ	1 гэрээ	Роялти орлого × 0.3 — Ахлах багшийн үзэлгээ нэг кредитийн үзэлгээ	Их сургуулийн эзэмшилтэй оюуны өмчийг түшиглэн лицензийн гэрээг байгуулж их сургуульд роялти орлого төвлөрүүлсэн бол тооцно. Кредитийг лицензийн гэрээнд хамаарах оюуны өмчийн зохиогч тус бүрд ижил тэнцүү олгоно.
8.4.9	Гарааны компани байгуулах - Компанийн үүсгэн байгуулагч - Хамтран оролцогчид	1 гарааны компани	3 1	Инновацын тухай хуулийн 3.1.8-д заасан гарааны компани байх ба тухайн хичээлийн жилд байгуулагдсан байна. Үүсгэн байгуулагч болон хамтран оролцогчдыг тодорхойлоходоо компанийн дүрэм болон инновацын төслийн багийн мэдүүлгийг үндэслэж тус бүрд кредитийг бүтэн тооцно.



8.5. Төсөл, гэрээт ажил, редакторласан бүтээл, суралцагчийн эрдэм шинжилгээ, инновацын үйл ажиллагаанд дараах кредит тооцно.

Хүснэгт 8.5. Төсөл, гэрээт ажил, редакторласан бүтээл, суралцагчийн эрдэм шинжилгээ, инновацын үйл ажиллагаа

Д/д	Бүтээлийн төрөл	Хэмжих нэгж	Кредит	Тайлбар
8.5.1	ШУТИС-д судалгаа дэмжих мөнгөн орлого төвлөрүүлж буй төсөл, гэрээт ажил.	1 ажил	X Шимтэл Ахлах багшийн нэг кредитийн чуултээ)	Удирдагчийн тодорхойлсон оролцооны хувиар тооцно. К-Оролцооны хувь
8.5.2	ШУТИС-д хэрэгжсэн техникийн туслалцааны төслийн хүрээнд нийлүүлсэн лабораторийн тоног төхөөрөмж	1 ажил	5	1 ажил гэдэгт тоног төхөөрөмжийн нийт өртөг нь нэг зуун сая төгрөгөөс дээш бол 5 хүртэлх кредитийг бүрэлдэхүүн, салбар сургуулийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрээр нэг удаа олгоно.
8.5.3	Сурах бичиг; Нэг сэдэвт бүтээл (Монограф); Мэргэжлийн ном	1 х.х.	0.1	Бүтээл нь эрдмийн зөвлөл эсвэл сурах бичгийн зөвлөлөөр дэмжигдсэн байна. Техникийн редакцыг тооцохгүй.
8.5.4	Сэтгүүлийн зөвлөлийн эрхлэгч, гишүүн - Олон улсын - Дотоодын	1 сэтгүүл	0.5 0.3	
8.5.5	Орчуулгын бүтээл (Зохиогчийн зөвшөөрөлтэй, ШУТИС-ийн захиалгат)	1 х.х.	0.08	
8.5.6	Гарын авлага (лабораторийн заавар, дасгал ажлыг тооцохгүй)	1 х.х.	0.05	ШУТИС-ийн профессор, багш нарын ном, сурах бичиг, сургалтын материал бичиж хэвлүүлэхэд баримтлах журам"-ын шаардлагыг хангасан байна. Кредитийг зохиогчийн оролцоогоор хувааж олгоно.
8.5.7	Өгүүлэлд шүүмж бичих ³ - гадаад хэл дээрх өгүүлэлд шүүмж бичих - монгол хэл дээрх өгүүлэлд шүүмж бичих	1 өгүүлэл	0.3 0.1	Шүүмжид ажлын хэлс авдаг бол давхцуулан тооцохгүй.
8.5.8	Эрдэм шинжилгээ, технологи, инновацын уралдаан, тэмцээнд суралцагч удирдаж 1-ээс 3-р байр эзэлсэн эсвэл оролцсон: - Олон улсын хэмжээнд - Улсын хэмжээнд - Их сургуулийн хэмжээнд - Бүрэлдэхүүн, салбар сургуулийн хэмжээнд - Удирдаж оролцуулсан	1 ажил	2.0 1.0 0.7 0.5 0.3	Бусад цагийн заалтай давхцуулж тооцохгүй, удирдагч нэгээс олон бол кредитийг хувааж тооцно. Суралцагчийн хамгийн өндөр амжилтад харгалзах кредитээр тооцно.

³ Scopus, Web of Science, DOAJ, Dimensions-д бүртгэлтэй сэтгүүлийн өгүүллийг тооцно. ШУТИС-ийн олон улсын сэтгүүлийн зөвлөлийн гишүүнд хамаарна. Дотоодын ЭШ-ний өгүүллийн хувьд ШУТИС-ийн мэргэжлийн сэтгүүлийн жагсаалтыг баталсан тушаалыг үндэслэн тооцно.

**ЕС. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН АЖЛЫН КРЕДИТИЙН
ТООЦОО**



9.1. Профессор, багш хүснэгт 9.1-д заасан мэргэжлийн үйлчилгээ, нийгмийн хариуцлагын 4 чиглэлийн ажлын 2-оос доошгүй чиглэлд ямар нэгэн ажил гүйцэтгэсэн байх ба ажлын гүйцэтгэлийг холбогдох тайлан, нотлох баримтад үндэслэн гаргана.

9.2. Тухайн ажлын цар хүрээг харгалzan тооцож болох жишиг цаг, түүнд харгалзах жишиг кредитийг хүснэгт 9.1-д үзүүлсэн ба нотлох баримтад үндэслэн бодит гүйцэтгэл гаргана.

Хүснэгт 9.1. Мэргэжлийн үйлчилгээ, нийгмийн хариуцлагын ажилд оногдох кредит

д/д	Ажил	Хэмжих нэгж	Жишиг кредит	Жишиг цаг
Чиглэл 1: Удирдлага зохион байгуулалт, бодлого, төлөвлөлтийн ажлууд				
1	ШУТИС-ийн болон бүрэлдэхүүн, салбар сургуулийн эрдмийн зөвлөлийн гишүүнээр ажиллах /давхардуулж тооцож болно/.	Оролцсон хурал бүрд	0.04	2
2	Улс, салбар, ШУТИС, бүрэлдэхүүн, салбар сургууль, тэнхимийн түвшинд удирдлага зохион байгуулалт, бодлого төлөвлөлт, сургалт, эрдэм шинжилгээний чиглэлээр зөвлөл, ажлын хэсэгт ажиллах (Ажлын хэлс аваагүй тохиолдолд)	Зөвлөл, ажлын хэсгийн хурал бүрд	0.04	2
3	Бусад тэнхимийн сургалтын хөтөлбөрийн урьдчилсан болон үндсэн магадлан итгэмжлэлийн ажилд зориулж материал бэлтгэж өгөх: - Гадаадын магадлан - Дотоодын магадлан	1 хөтөлбөр	0.5 0.3	24 14.4
4	Элсэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр санаачлан зохион байгуулсан, маркетинг, сурталчилгаа хийсэн ажлууд	1 арга хэмжээ	0.1	4.8
Чиглэл 2: Суралцагчдын хөгжил, төлөвшилд чиглэсэн ажлууд				
1	Зөвлөх багшаар ажиллах: - Бакалавр: 1-30 хүртэл оюутанд - Бакалавр: 30-аас дээш оюутан	1 улирал	0.5 0.7	24 33.6
2	Суралцагч, оюутны клуб, дугуйлан зохион байгуулах, удирдах	Хичээлийн жил	0.5	24
3	Суралцагчдад хичээлээс гадуур тодорхой сэдвээр давтлага өгөх, тойм лекц үнших	1 удаагийн лекц, давтлага	0.04	2
4	Олимпиад, уралдаан, тэмцээн, соёл, олон нийтийн ажил зохион байгуулах, комисст ажиллах - Бүрэлдэхүүн, салбар сургуулийн хэмжээнд - ШУТИС-ийн хэмжээнд - Улсын хэмжээнд - Олон улсын хэмжээнд	1 арга хэмжээ	0.3 0.5 0.8 1.0	14.4 24 38.4 48
6	Нийгмийн сайн сайхны төлөө суралцагчдыг хамруулан хүмүүнлэгийн ажил зохион байгуулах (Ургац хураалт, мод тарих, орчны цэвэрлэгээ гэх мэт)	1 ажил	0.2	9.6
Чиглэл 3: Багшийн хөгжил, төлөвшилтэй холбоотой ажлууд				
1	Багшийн хичээлд сууж зөвлөгөө өгөх, өөрөө багшийн хичээл сууж дагалдан суралцах	1 удаа	0.04	2

2	ШУТИС-ийн хэмжээнд зохион байгуулагддаг урлаг, спортын уралдаан, тэмцээн, нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажилд оролцох	1 арга хэмжээ TTA11161.9087087	0.3	14.4
3	Багш дадлагажуулж сургах	1 багш	0.5	24
4	Нээлттэй семинар хэлбэрээр сургалт, эрдэм шинжилгээний чиглэлээр илтгэл хэлэлцүүлж туршлагаа түгээн дэлгэрүүлэх	1 илтгэл	0.04	2
5	Багш өөрийн санаачилгаар мэргэжлийн дагуу болон боловсролын чиглэлийн сертификаттай (батламж) сургалтад хамрагдах	1 сургалт	0.5	24

Чиглэл 4: Багшийн мэргэжлийн үйлчилгээтэй холбоотой ажлууд

1	Лаборатори, кабинет хариуцан ажиллах (сургалтын мастер хариуцаагүй тохиолдолд)	1 хичээлийн жилд	1	48
2	Лаборатори, кабинетад шинээр тоног төхөөрөмж суурилуулах, тохижуулах, холбогдох баримт бичгийг боловсруулах	1 ажил	0.8	38.4
3	Мэргэжлийн холбоо, Төрийн бус байгууллагыг удирдан зохион байгуулах, тэргүүлэн ажиллах	1 хичээлийн жилд	0.5	24
4	Олон нийтэд мэдлэг түгээх, нийгмийг соён гэгээрүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний хялбаршуулсан ба сурталчилгааны өгүүлэл, нийтлэл хэвлүүлэх	1 өгүүлэл, нийтлэл	0.3	14.4
5	Мэргэжлийн дагуу үндэсний зөвлөх, шинжээчээр ажиллах (Ажлын хөлс аваагүй тохиолдолд)	1 ажил	0.3	14.4
6	TV, радиогийн нэвтрүүлгээр сургууль, хөтөлбөр, мэргэжлээ сурталчлан таниулах, нэвтрүүлэг, мэтгэлцээнд оролцох, ярилцлага өгөх, лекц, танилцуулга хийх, нийгмийн сүлжээнд контент бэлтгэн түгээх	1 ажил	0.1	4.8
7	Ажил олгогчдын өдөрлөг, сургуулийн нээлттэй өдөрлөг зохион байгуулах	1 ажил	0.2	9.6
8	ШУТИС-ийн сургалт, эрдэм шинжилгээ, инновацын ажлын бүртгэлд тусгагдаагүй ажил гүйцэтгэх	1 ажил	0.3	14.4

-----Оо-----